




ХАМТЫН ӨСӨЛТ ТӨГӨЛДӨР


Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2023 оны эхний хагас жил




2021-2023 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ҮНДСЭН ЗОРИЛТУУД



**ХАРИЛЦАГЧ
ТӨВТ БИЗНЕС**



**БИЗНЕСИЙН ӨСӨЛТ БА
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**




**ЦАХИМ БАНКААР
ТҮҮЧЭЭЛЭГЧ**



**БАЙГУУЛЛАГЫН
ХӨГЖИЛ**

ХАРИЛЦАГЧ ТӨВТ БИЗНЕС

Гүйлгээ хийж буй харилцагчдын тоо оны эцсээс өсөлттэй хэвээр байна.



52% цахим сувгийн идэвхтэй хэрэглээ

Банк доторх гүйлгээний хураамжийг **50%** бууруулав.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

- Багш нарт тусгайлан зориулсан карт**
Монгол улсын боловсролын салбарт ажиллаж буй нийт багш нарт зориулсан тухайлсан хөнгөлөлт урамшуулалтай олон улсын картыг нэвтрүүллээ.
- еKYS - Харилцагчийн зайны бүртгэл**
Харилцагч хувийн мэдээллээ зайнаас шинэчлэх боломжийг бүрдүүлсэн үйлчилгээ ба Интернет банк болон Киоск машинаас баталгаажуулах боломжтой боллоо.
- Картын онлайн захиалга**
Харилцагч дебит картыг Киоск машинаар захиалах, нөхөн авах, кредит картыг Интернет банкаараа нөхөн авах боломжуудыг бүрдүүллээ.
- Онлайн даатгал үйлчилгээ**
Тээврийн хэрэгсэлийн даатгалыг харилцагч онлайнар даатгуулах боломжийг бүрдүүллээ.
- Факторингийн үйлчилгээ**
Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтын факторингийн үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүллээ.
- Онлайн тэтгэврийн зээл**
Тэтгэврийн зээлийг Khan Bank аппликэйшн, Киоск машинаар зайнаас авах боломжийг бүрдүүллээ.
- Онлайн малчны зээл**
Хөрөнгө худалдан авах болон хэрэглээний зориулалтаар Khan Bank аппликэйшнээр малчны зээлийг зайнаас авах боломжийг бүрдүүллээ.
- Ногоон санхүүжилт, тогтвортой санхүүжилтийн зээлүүд**
Ногоон тээврийн хэрэгслийн зээл, Тогтвортой ноос ноолуурын нийлүүлэлтийг дэмжих зээл, Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины сууцны зээлүүдийг хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлтэйгээр санал болгож байна.
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зээлүүд**
Засгийн газар, Сангийн яамны дэмжлэгтэйгээр УБ хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдийг дэмжих, орон нутагт шилжин суурьшиж анх удаа орон сууц худалдан авч буй иргэдийг дэмжих зорилгоор бизнесийн болон орон сууцны ипотекийн зээлүүдийг шинээр нэвтрүүллээ.
- Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээл**
Эмэгтэй жижиг, дунд бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих зорилгоор бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, хүүгийн хөнгөлөлт үзүүлэх бизнесийн зээлүүдийг нэвтрүүллээ.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон ХХААҮ-ийг дэмжих зээл**
Хүнс, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, сав, баглаа боодол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, хоршоод, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор зориулалтын дагуу тухайлсан нөхцөл бүхий төслийн зээлүүдийг нэвтрүүллээ.

АЯН, УРАМШУУЛАЛТ ХӨТӨЛБӨР



Залууст зориулан К картын урамшуулалт аян

Аяны хүрээнд GS25, Caffe Bene, Alpha book гэх мэт 24 байгууллагаар үйлчлүүлэхэд 20% буцаан олголтын урамшуулалттай нөхцөлийг санал болгож амжилттай хэрэгжүүллээ.




Бизнесийн зээлийн аян

Бизнес эрхлэгч харилцагчдын хэрэгцээ шаардлагад нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр санал болгох зорилгоор уламжлалт бизнесийн зээлийн аяныг зохион байгууллаа.



Хишиг дүүрэн цагаан сар- Кредит картын буцаан олголтын аян

Аяны хүрээнд ХААН Банк кредит карттай харилцагч Номин, Оргил сүлжээ дэлгүүр гэх мэт сонгогдсон 32 байгууллагаар үйлчлүүлэхэд 10% буцаан олголтын урамшуулалттай нөхцөлийг санал болгож амжилттай хэрэгжүүллээ.




Хэрэглээний зээлийн аян

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ХААН Банкны хэрэглээний зээлийн аян 2023 оны хувьд хэрэглээний зээлүүдийг харилцагч боломжит сувгуудаар зайнаас авах нөхцөлийг бүрдүүлж, бүрэн цахимжсанаараа онцлог байлаа.



"TEEN" картын 5% буцаан олголтын аян

Эх үрсийн баярыг угтаж, 7-17 насныханд зориулсан "TEEN" хүүхдийн карттай харилцагчдынхаа дунд БУЦААН ОЛГОЛТЫН УРАМШУУЛАЛТ АЯН зарлаж хэрэгжүүллээ.





"Буюнт малчин таны хишиг арвижиг" хадгаламжийн урамшуулалт аян

Хуримтлалтай иргэнийг бий болгох, санхүүгийн зөв дадал хэвшүүлэх, санхүүгийн дархлааг дэмжих, хуримтлуулах сэдлийг нь урамшуулах зорилгоор ХААН Банкнаас 21 аймгийн малчид болон малчин өрхүүдийнхээ дунд "Буюнт малчин таны хишиг арвижиг" уриатай хадгаламжийн урамшуулалт аяныг зохион байгууллаа.

БИЗНЕС ӨСӨЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


НИЙТ ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)




ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)



БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)




ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Чанаргүй активыг бууруулах стратеги 2023-2027”, “Банкыг тогтворжуулах төлөвлөгөө”-г боловсруулан, гүйцэтгэлийг хянан ажиллаж байна.

Банк үнэлгээний аргачлалыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх зорилгоор Базел стандартын Бүлэг 2-ын аргачлалуудыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)

ОНЛАЙН ЗЭЭЛИЙН БАГЦЫН БҮТЭЦ



ЦАХИМ БАНКААР ТҮҮЧЭЭЛЭГЧ


Технологийн шийдлүүд харилцагчдад үйлчилгээ үзүүлдэг процессыг шинэчилсээр байна.

Nº1

Дижитал банк

99.9%

Системийн бэлэн байдал



Цахим банкны шинэчлэл, сайжруулалтыг тогтмол хийж, системийн бэлэн байдлыг 99.9% хангаснаар цахим банктай харилцагчийн тоо оны эцсээс 77.3 мянгаар өслөө.

2 минут

Харилцагч нэгж дээр 16.5 минут зарцуулдаг байсан.

366 мянга

Хувийн мэдээлээ зайнаас шинэчилсэн.



Харилцагчийн хувийн мэдээлэл зайнаас шинэчлэх eKYC төслийг Интернет банк болон Киоск машин дээр нэвтрүүлээ. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 366 мянган харилцагч зайнаас мэдээллээ шинэчилсэн.

2X

Зээл олголтын тоо

21.4%


Нийт зээлийн багцад онлайн зээлийн эзлэх хувь



Харилцагч бүх төрлийн хэрэглээний зээл болон ПОС-ын орлого барьцаалсан зээлийг онлайнаар авах боломжийг бүрдүүлснээр зээл олголтын тоо 2 дахин нэмэгдэж, эхний хагас жилд давхардсан тоогоор 1.4 сая олголт хийгдсэн ба нийт зээлийн багцын 21.4%-ийг онлайн зээл эзэлж байна.

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

ХААН БАНК IPO



ХААН Банк 2023 оны 4-р сард нээлттэй хувьцаат компани болж хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжсан ба 2023 оны 6-р сарын 24-ний өдрөөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа.

ДИЖИ КОРНЕР

ХААН Банк GS 25 сүлжээ дэлгүүрийг түшиглэн, АТМ болон Киоск машин хосолсон “Дижикорнер” дижитал цэгүүдийг нээн ажиллуулж байгаа ба 2023 оны 2-р улирлын байдлаар өөртөө үйлчлэх 5 цэгийг байгуулаад байна. 2023 онд багтаан нийт 50 байршилд байгуулахаар ажиллаж байна.



ДИЖИТАЛ САЛБАР



ХААН Банк өөртөө үйлчлэх дижитал салбарыг байгуулахаар төлөвлөсөн ба “Digi Go” дижитал салбарын хувьд эхнийх нь Хан-Уул дүүргийн Яармагт байрлах ХААН Банкны Белмонте салбарын хажууд нээгдсэн. 2023 онд багтаан нийт 10 байршилд байгуулахаар ажиллаж байна.

ХАЙБРИД БОЛОН СМАРТ ОФФИС

ХААН Банк ажилтнуудын зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэх, хайбрид оффис төслийг хэрэгжүүлснээр нийт ажилтны 30% тогтмол зайнаас ажиллаж байна. Мөн Смарт оффис төслийн хүрээнд цахим борлуулалтын ажилтантай болж орон нутгийн ажилтнууд зайнаас ажиллах боломжтой болсон.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ УРТ ХУГАЦААТ САНХҮҮЖИЛТ

УРТ ХУГАЦААТ ЭХ ҮҮСВЭР

(2007-оос 2023.06.30-ны хооронд)

\$1,700,000,000



УРТ ХУГАЦААТ ЭХ ҮҮСВЭР

(2023.01.01-2023.06.30-ны хооронд)

\$225,000,000



ХААН Банк 2023 онд урт хугацаат эх үүсвэр \$225,000,000 татсан.

МОНГОЛ УЛСЫН АНХНЫ НОГООН БОНД

(2023.03.31-ний байдлаар)

\$60,000,000




ХААН Банк 2023 онд 60 сая ам.долларын анхны ногоон бондыг олон улсын зах зээлд гаргасан ба 2023 оны 6-р сард 30 сая ам.долларын дотоодын ногоон бондын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан.




ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА НОГООН САНХҮҮЖИЛТ

НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ



НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

Монгол Улсын Ногоон таксономын ангиллаар



■ Эрчим хүч хэмнэлт ■ Сэргээгдэх эрчим хүч ■ Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал ■ Ногоон барилга
■ Карбон бага ялгаруулдаг тээвэр ■ Бохирдлоос сэргийлэх, буруулах үйл ажиллагаа ■ Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

500 ТӨСӨЛД **9.7** ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

БАЙГАЛЬ ОРЧИН



“ХААН Банкны ой” хөтөлбөр
Мазаалайг аврах төсөл

НИЙГЭМ БА ХӨГЖИЛ



Тогтвортой хөгжлийн бодлого
Монголын уран зургийн галерей дахь
виртуал галерей
3x3 сагсан бөмбөгийн талбай

ЭРҮҮЛ МЭНД



Хавдрын эсрэг үндэсний аян
Цусны даралт ихсэлтийн
Эсрэг аян


БОЛОВСРОЛ



“Ирээдүй” санхүүгийн
Боловсролын хөтөлбөр
ХААН Банкны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр
Сургуулийн орчныг сайжруулах төсөл

БИДНИЙ АМЖИЛТУУД

ЭХНИЙ ХАГАС ЖИЛ АМЖИЛТ БҮТЭЭЛ ДҮҮРЭН БАЙЛАА.



IRO ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Цахим шилжилт, мэдээлэл технологийн хөрөнгө оруулалт

35%

64.1 тэрбум төгрөг

Зарцуулалт: **5134.3 сая төгрөг**
Эх үүсвэрийн үлдэгдэл: **58.9 тэрбум төгрөг**

ХААН Банк нь 2023-2024 оны хооронд мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад хэд хэдэн стратегийн зорилтуудыг тодорхойлсон.

Үүнд:

- Үүлэн технологийн шинэчлэлт
- Өгөгдлийн нөөцлөлт, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Дижитал шилжилт
- Процесс автоматжуулалтууд

Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт

34%

62.4 тэрбум төгрөг

Зарцуулалт: **0 төгрөг**
Эх үүсвэрийн үлдэгдэл: **62.4 тэрбум төгрөг**

- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины сууцны зээл, амьдрах нөхцөлөө сайжруулах зээл, барилгын ногоон зээл гэсэн 5 төрлийн бүтээгдэхүүн шинээр санхүүжүүлэхээр болсон.

Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт

31%

56.9 тэрбум төгрөг

Зарцуулалт: **56.9 тэрбум төгрөг**
Эх үүсвэрийн үлдэгдэл: **0 төгрөг**

- Урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилт 258 харилцагчийн 56.9 тэрбум төгрөгийн 36-84 сарын хугацаатай хөрөнгө оруулалтын зээлүүдийг олгосон.







САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2023 оны эхний хагас жил

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)




АШИГТ АЖИЛЛАГАА БОЛОН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)


ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ

Тайлант жилийн эцсээрх харьцуулалт
(сая төгрөг)



ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ


Эхний хагас жилийн байдлаарх харьцуулалт
(сая төгрөг)




1-Р ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА




ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА




АКТИВЫН ӨГӨӨЖ




ӨХ-Н ӨГӨӨЖ



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА




ЗЭЭЛ ДЕПОЗИТЫН ХАРЬЦАА



(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

ЗАХ ЗЭЭЛ ЭЗЛЭЛТ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ




НИЙТ ЗЭЭЛ



ХАРИЛЦАГЧИЙН ДЕПОЗИТ



НИЙТ ЦЭВЭР АШИГ



Зах зээл эзлэлтийн үзүүлэлтүүдийг Монголбанкны тайланд суурилан тооцов.

**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА**